


Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

**НИЙТИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ХООЛ ТЭЖЭЭЛ, ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН
ЖАРГАЛСАЙХАН ОВОГТОЙ АЛТАНСУВДЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**


Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэ лтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	6		
1	2	3	4	5	7			
Зорилт 1. “Хоол тэжээлийн бодлогын хэрэгжилтийн зохицуулалт” зорилтын хүрээнд								
1.1	Эхийн сүүний нөөцийн банк байгуулж, ажиллуулах журмыг батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Журмын төсөл боловсруулж байгууллагууд аас санал авсан	Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулж, эрүүл мэндийн байгууллагад хүргүүлсэн байна.	Эхийн сүүний нөөцийн банк ажиллуулах журмын төслийг боловсруулах бэлтгэл ажлын хангаж шаардлагатай материал цуглуулах хүрээнд ДЭМБ-ын Зүүн өмнөд Азийн “Эхийн сүүний банкны стандарт”-ыг орчуулсан. Эхийн сүүний нөөцийн банкны журмын тесөл боловсруулах ажлын хүрээнд ЭМЯ, НЭМҮТ, НҮБ-ын Хүүхдийн сангийн төлөөллийг оролцуулсан уулзалт зохион байгуулж, ажлын төлөвлөгөө гаргасан. Журмын эхний төслийг боловсруулж, холбогдох газруудаас санал авах албан бичгийг хүргүүлсэн. ЭХЭМҮТ,	2024.06.25 2024.12.31	50%	




					ЭНЭҮТ-2, Өргөө, Хүрээ амаржих газрууд, Интермед эмнэлгээс ирүүлсэн саналыг тусган эхийн сүүний нөөцийн банк байгуулах журмын төслийг эцэслэн боловсруулж, газар хэлтсийн дарга нараар хянуулан тойруулж байна.		
1.2	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалыг шинэчлэн батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаал	Тушаалыг шинэчлэн батлуулж, байгууллагууд ад хүргүүлж мэдээллээр ханган ажилласан байна.	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 27 тоот албан бичгээр ирүүлсэн Эрүүл мэндийн сайдын 2017 оны "Хоногийн хоол хүнсээр авбал зохих илчлэг, үндсэн шимт бодис, амндэм, эрдэс бодисын зөвлөмж хэмжээ батлах тухай" А/74 дүгээр тушаалыг шинэчлэхэд оруулах саналыг үндэслэн тушаалын төслийг боловсруулсан. ХХААХҮЯ, Үндэсний статистикийн хорооны холбогдох албаны хүмүүстэй 2 удаагийн уулзалт зохион байгуулж, хэлэлцүүлсэн. НЭМҮТ-өөс ирүүлсэн саналыг үндэслэн А/74 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралт болох "Жишсэн дундаж хүний илчлэг, шимт бодисын хоногийн зөвлөмж хэмжээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ"-нд өөрчлөлт оруулах тухай Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг	2024.06.25 2024.12.31	50%

144




					боловсруулсан газар хэлтсийн дарга нараар саналыг аван эрүүл мэндийн сайдаар батлуулахад бэлэн болоод байна.		
1.3	Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр 2024-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулсан	Төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр 2024-2027 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилт, нийт 38 үйл ажиллагаатайгаар боловсруулж, ЭМЯ-ны удирдлагуудад тойрох хуудсаар танилцуулсан БТГ-аас хүнсний аюулгүй байдлын тусгайлсан арга хэмжээний төлөвлөгөө байх шаардлагагүй гэсэн санал өгсөн тул төлөвлөгөөний төслийг дахин боловсруулж, 2024-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болгон Эрүүл мэндийн Дэд сайдаар батлуулахад бэлэн болсон байсан боловч, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөн тул төлөвлөгөөний төслийг дахин боловсруулж, удирдлагуудад танилцуулан, саналыг авч байна.	2024.06.25 2024.12.31	50%
1.4	ЗГУАХ 2.3.2.6 Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх, бусад салбартай хамтран ажиллах	Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 30 хувьд хүргэсэн байна.	2023 оны БШУ-ны сайд, ЭМ-ийн сайд, ХНХ-ын сайдын А/236, А/189, А/80 дугаар	Арга хэмжээг төлөвлөгөөний 2024 оны үйл ажиллагаа хэрэгжсэн байна	2024 оны 03 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон тооны бус зөвлөлийн хуралдаан”-д эрүүл мэндийн салбарт 2023 онд хийсэн үйл ажиллагааны	2024.06.25 2024.12.31	100%



			<p>Имтарсан тушаал</p> <p>тайлан, 2024 оны төлөвлөгөөг танилцуулсан. “Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих орон нутгийн орон тооны бус зөвлөл”-ийн гишүүдийг чадавхжуулах тус бүр 100 хүнтэй 2 удаагийн сургалтыг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамтай хамтран зохион байгуулсан. 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Зөвлөлийн даргаар Эрүүл мэндийн сайд ажиллаж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p><i>2.1</i></p> <p><i>2.2</i></p> <p><i>2.3</i></p> <p><i>3.1</i></p> <p>Нярай, бага насны хүүхдийн хооллолтын талаарх зөвлөгөө өгөх сургалтыг 12 аймаг, 2 дүүрэгт зохион байгуулж, нийт 540 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхжуулав. “Олон нийтэд түшиглэсэн нялх, бага насны хүүхдийн хооллолтын дэмжлэгт хяналт, зөвлөгөө-хяналт шинжилгээ” тандагч бэлтгэх сургалт: 22 сургач багш бэлдсэн.</p> <p>Хоол тэжээлийн цочмог дутглын цогц менежмент сургалтыг зохион багуулж нийт 21 аймаг 9 дүүргийн 85 эмч нарыг хамруулан сургаж чадавхжуулав.</p>	
--	--	--	--	--

1.8-дамж-х
2.12
2.14.


1.9-х
2.10-х
3.4-х
3.6-х



Олон нийтэд түшиглэсэн нялх бага насын хүүхдийн хооллолтын зөвөлгөө сэдэвт сургалтад 14500 эцэг эх асран хамгаалагч нарыг хамруулсан.
Эх хүүхдийн эрүүл мэндийн ягаан дэвтрийг цахимжуулах ажлыг эрчижүүлж, хүүхдийн хөгжлийг хянах МОРБАС агуулга нэмж оруулсан.


Зорилт 2. “Хүнсний аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийн зохицуулалт” зорилтын хүрээнд

2.1	Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдэлийг үнэлэх журмыг батлуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал	Журмын тесөл боловсруулж байгууллагууд аас санал авсан, салбар хооронд хэлэлцүүлсэн	Журмыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулж байгууллагууд ад хүргүүлсэн.	Шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсний эрсдэлийг үнэлэх журмын төслийг газар хэлтсийн дарга нараар танилцуулж батлуулахаар эрүүл мэндийн сайдын тесөлд газар хэлтсийн дарга нараар саналыг аван Эрүүл мэндийн сайдад хянагдаж байна.	2024.06.25 2024.12.31	50%
2.2	Хүнсний бүтээгдэхүүний зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг ХХААХҮЯ-тай хамтран батлуулах	ХХААХҮ-ийн сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаал	ХХААХҮ-ийн сайд, ЭМ-ийн сайдын 2019 оны А/166, А/251 дугаар хамтарсан тушаал	Хамтарсан тушаалыг батлуулж, Холбогдох байгууллагууд ад хүргүүлж мэдээллээр хангасан байна	ХХААХҮЯ-нд холбогдох саналыг хүргүүлсэн ба тесөлд санал авч ХХААХҮЯ-нд боловсруулагдаж байна. ХХААХҮЯ-тай хамтран сүү сүүн бүтээгдэхүүний техникийн зохицуулалтыг шинэчлэн батлуулахаар засгийн газарт өргөн бариад байна.	2024.06.25 2024.12.31	50%
2.3	ЗГУАХ 2.3.10.1 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын стандартын хэрэгжилтийг хангахад хамтран ажиллах	Хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нары тайлан	“MNS 7005: 2023 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн	Стандартыг хэрэгжүүлэхэд хамтран ажилласан байна.	Стандарт хэмжил зүйн газрын 2023 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн “MNS 7005: 2023 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн	2024.09.01 2024.12.31	100%




			хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага”	хоол үйлчилгээнд шaanдаarдлага” стандарт шинээр батлагдсан ба тус стандартыг 2024 оны 1 дүгээр сарын 1- ний өдрөөс эхлэн мөрдөж байна. “Сургуулийн хоол үйлдвэрлэлд тавих хяналтын журам” батлах тухай Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын 2024 оны 04 дүгээр сарын 16- ны өдрийн A/78, A/238, A/173 дугаар хамтарсан тушаалыг батлуулж, Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн сангийн 6836 дугаарт 2024 оны 05 дугаар сарын 24- ний өдөр бүртгүүлсэн. Уг журмын дагуу ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж байна. Дээрх журам батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Шадар сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын хамтран баталсан 2022 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 28/A/108/A/180 дугаар тушаалыг 2024 оны 06 дугаар	үйлдвэрлэл, тавих шaaардлага”	
--	--	--	---	--	-------------------------------------	--

2



					сарын 24-ний өдрийн 44/A/308/A/291 дүгээр хамтарсан тушаалаар хүчингүй болгосон.		
2.4	Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 14.1 Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг батлуулах	Засгийн газрын тогтоол		Техникийн зохицуулалтыг боловсруулан батлуулж байгууллагууд ад хүргүүлсэн байна.	"Импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалт"-ыг шинэчлэн боловсруулж батлуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" А/84 дүгээр тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн хурлаар техникийн зохицуулалтын эхний төслийг боловсруулж, 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 6/1432 дугаар албан бичгээр холбогдох газруудад хүргүүлэн саналыг авч нэгтгэн, сайжруулалтыг хийсэн. Журмын төслийг хэлэлцүүлэх ээлжит хурлыг 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж төслийг засварлан боловсруулсан. Журмын төсөлд 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 6/2913 дугаар албан бичгээр дээрх газруудаас дахин санал авч, нэгтгэн журмын төслийг эцэслэн боловсруулсан. Журмын төслийг Засгийн газрын	2024.07.01 2024.12.31	100%

67




<p>хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн 1а/3858 тоот албан бичгээр яамдад хүргүүлж санал авсан. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн саналд Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн импортлох согтууруулах ундааны чанар, аюулгүй байдлын үзүүлэлтийн техникийн зохицуулалтыг батлуулах асуудлаар холбогдох этгээдийн саналыг авч, бүрдүүлбэрийг хангасны үндсэн дээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан санал авах нь зүйтэй гэж үзсэн тул Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 1а/5150 тоот албан бичгээр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хандан уг журмыг Засгийн газрын тогтоолоор батлуулах арга хэмжээ авах саналыг хүргүүлсэн.</p>						
3.1	ЭМССТ 1.12	Судалгааны ажлын тайлан	2017 онд хүн амын хоол тэжээлийн	Хүн амын хоол тэжээлийн VI	Хоол тэжээлийн VI судалгаанд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн 4 бүс	2024.07.01 2024.12.31

Зорилт 3. “Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын тандалт судалгаа” зорилтын хүрээнд


3.1	ЭМССТ 1.12	Судалгааны ажлын тайлан	2017 онд хүн амын хоол тэжээлийн	Хүн амын хоол тэжээлийн VI	Хоол тэжээлийн VI судалгаанд Монгол Улсын нийгэм, эдийн засгийн 4 бүс	2024.07.01 2024.12.31	100%
-----	------------	-------------------------	----------------------------------	----------------------------	---	--------------------------	------

180



	Хүн амын бол тэжээлийн VI судалгааны үр дүнг тооцож тайлан гаргах		Дэсний V судалгаа хийгдсэн	судалгааны үр дүнг тооцож тайлан гаргаж, байгууллагууд ад хүргүүлж мэдээллээр хангасан байна	(21 аймаг)-ийн 112 сум, Улаанбаатар хотын 8 дүүргийн 40 хорооны нийт 17423 хүнийг хамруулсан. Нийт 12 судалгааны багт 60 судлаачид ажилласан. Судалгааны мэдээллийн баазыг “EpiData 3.0” програмд үүсгэж, 7 төрлийн асуултын шивэлтийг хийж мэдээлэл тайлан боловсруулсан. Судалгааны үр дүнг баталгаажулахаар судалгаагаар цуглуулсан 4,144 ийлдэсний дээжийг Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Виллштат хот дахь “ВитМин” лабораторид илгээн төмөр, А аминдээмийн дутлыг илрүүлэх багц шинжилгээ хийлгэсэн. Судалгааны үр дүнг 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр НЭМҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар, 11 дүгээр сарын 27-ны өдөр ЭМЯ-ны дэргэдэх VI судалгааны удирдах зөвлөлийн хурлаар, 11 дүгээр сарын 28-ны өдөр салбар хоорондын 13 байгууллагын 25 эрдэмтэн, судлаач оролцсон уулзалт-хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан. Судалгааны үр дүн, тайлан гарч хэвлэгдсэн		
3.2	Биологийн идэвхт бүтээгдэхүүний бүртгэлийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, нэгдсэн	Бүртгэгдсэ н биологийн идэвхт	2023 онд шинээр бүртгэсэн 383, хугацааг	БИБ-ийн Салбар зөвлөлийн үйл	Биологийн идэвхит бүтээгдэхүүний салбар зөвлөлөөр 2024 онд шинээр бүртгэсэн 533, бүртгэлийн	2024.06.25 2024.12.31	100%


184



	бүртгэлийн тасралтгүй байдлыг хангаж ажиллах	бүтээгдэхүүний тоо	сүнгасан 98, өөрчлөлт орсон 44, бүртгэлээс хассан 2 бүтээгдэхүүн.	ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллана	хугацааг сунгасан 95, бүртгэлийн өөрчлөлт орсон 217, бүртгэлээс хассан 1 бүтээгдэхүүнийг хэлэлцэж нэгдсэн бүртгэлийн тасралтгүй байдлыг хангаж ажилласан.		
--	--	--------------------	---	--	---	--	--

Зорилт 4. “Эрүүл мэндийн боловсрол олгох, дэмжих чиглэлээр салбарын болон салбар хоорондын хамтын ажиллагааны зохицуулалт” зорилтын хүрээнд

4.1	УИХ-ын 36 дугаар тогтоол 5.10 Хоол, хүнсний зөв, зохистой, соёлтой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах	Зохион байгуулсан үйл ажиллагаа ны тоо, боловсруулсан мэдээлэл, сурталчилгаа, ааны материалын төрөл, тоо	2023 онд “Энэ жилдээ эрүүл жиндээ аян”, MYОНТ-тэй хамтран Эрүүл мэнд төлө сэтгүүл нэвтрүүлэг.	Хоол, хүнсний зөв, зохистой хэрэглээний талаарх сургалт, сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулсан байна.	“Энэ жилдээ-Эрүүл жиндээ 2” аяныг 2024 оны 02 дугаар сарын 01-нээс 03 дугаар сарын 31-ний өдрүүдэд үндэсний хэмжээнд зохион байгуулж, сошиал постер 38, видео рийлс 2, фото постер 8 боловсруулж олон нийтэд түгээсэн, том сурталчилгааны самбар 5 дүүргийн 10 байршилд, А3 самбарт 8 хотхонд 300 ширхэг сурталчилгааг байршуулсан. Аяны хүрээнд нийт 11 видео, 30ш зурган контент олон нийтэд цацаж нийт 754925 хүнд хүрч, 12533 удаа хуваалцсан байна. 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил”-ийн нээлтийн арга хэмжээний үеэр иргэд, олон нийт, хүүхдэд зөв зохистой хооллолт, эрүүл хүнсний талаар мэдээлэл, зөвлөгөө өгч, биеийн жингийн индекс тодорхойлох аргачлалыг	2024.06.25 2024.12.31	100% <i>зорох чадварыг зориулж</i> <i>зорох чадварыг зориулж</i>
-----	--	--	---	--	--	--------------------------	--




зааж, зөвлөгөө өгч ажилласан.


- Хүн ам, олон нийтийн эрүүл, зөв хооллолтыг дэмжих, эрүүл хүнсийг сонгон хэрэглэх талаар соён гэгээрүүлэх, боловсролыг дэмжих чиглэлээр 2024 онд давхардсан тоогоор 300 гаруй инфографик (зурагт зөвлөмж)-ийг бүтээж, нийтэд түгээсэн. Үүнд:

- Төвийн таргалалтыг үнэлэх, бусэлхийн тойргийг хэрхэн хэмжих талаар богино хэмжээний видео-1,
- хоол хүнсээр дамжих өвчнөөс урьдчилан сэргийлэх видео - 3,
- хоол хүнс, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр подкаст - 27,
- ТВ ярилцлага - 115,
- Сонин болон цахим сайтуудад- 15


21 аймгийн Эрүүл мэндийн газарт эрүүл хооллолтын “Гэр” зөвлөмж 1000 ширхэг зурагт хуудас түгээсэн.



4.2	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хоол тэжээлийн боловсрол олгох сургуульд сууринсан зохистой хооллолтын нөлөөллийн ажил зохион байгуулах	Үйл ажиллагаа ны төлөвлөгөө , тайлан		Сурагчдад зохистой хооллолтын мэдлэг олгох, нөлөөллийн ажил зохион байгуулсан байна	Fix My Food" Өсвөр үеийнхний нөлөөллийн компанийт ажил Монголын хүүхдийн зөвлөлтэй хамtran 30 хүүхдийг Англи улсын Bite Back ТББ-тай хамtran сургав. Нөлөөллийн уран бүтээл хийх, Сургуулийн хоол тэжээлийн орчны үнэлгээ зохион байгуулах гэсэн чиглэлээр 2024 оны 11дүгээр сарын 03-ны өдөр Монголын хүүхдийн зөвлөлийн гишүүн нийт 30 хүүхдүүдэд "Эрүүл хооллолт-Эрүүл ирээдүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургуулийн хоол тэжээлийн орчны үнэлгээ хийх аргачлалыг танилцуулах сургалтыг зохион байгуулсан. НЭМҮТ, МХЗ, БЕГ хамtran "Ерөнхий боловсролын сургуулийн хоол тэжээлийн орны үнэлгээ" аргачлалыг ашиглан Нийслэлийн 10 сургуулийн хоол тэжээлийн орчныг үнэлэн цаашид авах арга хэмжээний санал, дүгнэлт гаргасан.	2024.09.01 2024.12.31	100%
4.3	Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулах	Зохион байгуулсан болон хэрэгжүүлс эн үйл ажиллагаа ны тоо, тайлан	"Эхийн сүүгээр хооллолтыг дэмжье, хамгаалья" хэлэлцүүлэг, уулзалт, сургалт	Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулна.	1. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих дэлхийн 7 хоногийн хүрээнд 2024 оны 08 дугаар сарын 02-нд Улсын болон хувийн хэвшлийн төрөх эмнэлэг, төрсний дараах сувилал, дүүргийн эрүүл мэндийн төвүүд, аймгийн эрүүл мэндийн газруудын	2024.06.25 2024.12.31	100%



					чанаарын менежер, төрөх, нярайн тасгийн эрхлэгч нийт 57 эрүүл мэндийн ажилтанд сургалт 10 төрлийн инфографик, нэг төрлийн телевизийн видео шторк, нэг төрлийн богино бичлэг, 7 хоногийн уриа, мессеж агуулсан 1 төрлийн постер бүтээж олон нийтэд түгээсэн . 2.Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхмыг хэрэгжүүлэх нь” цахим сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 07-14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтад Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймгийн нийт 119 сум, тосгоны эрүүл мэндийн төвийн ажилтнууд хамрагдсан.	<i>10 ажсан</i>	<i>10 ажсан</i>
4.4	Аймаг нийслэлийн хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, эрүүл мэндийн мэргэжилтэнг хоол тэжээлийн чиглэлээр чадавхижуулах сургалт зохион байгуулах	Зохион байгуулсан сургалтын тоо	“Олон нийтэд түшиглэсэн нялх, бага насны хүүхдийн хооллолтын зөвлөгөө” орон нутгийн 100 сургагч багш бэлтгэсэн.	Эрүүл мэндийн мэргэжилтнүү дэд мэргэжилтэй зүйн зөвлөгөө өгч сургалт зохион байгуулсан байна	1.Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтнүүд, эмнэлэг, сувиллын эмч, хоол зүйч, тогооч зэрэг нийт 100 хүнд “Хоол эмчилгээний удирдамж” А/440 -ийг танилцуулах уулзалтыг 2024 оны 2-р сарын 05-нд цахимаар зохион байгуулсан. 2. “Эрүүл хооллолт-Эрүүл ирээдүй” сэдэвт сургалтыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, боловсролын	2024.09.01 2024.12.31	100%




газрын мэргэжилтэн, ерөнхий боловсролын сургуулийн эмч, хоол зүйч, эрүүл мэндийн хичээлийн багш нийт 680 хүнд зохион байгуулсан. Тус сургалтаар “Хоол яагаад чухал вэ?”, “Хооллолт эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөх вэ”, “Бид юу идэх хэрэгтэй вэ?”, “Эрүүл бус хүнс ба эрүүл мэнд” сэдвүүдээр мэдээлэл хүргэсэн.

3. 21 аймаг, 9 дүүргийн 90 гаруй ЭМА-уудад “ЭМБ дахь олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн хангамж, хүртээмжийн өнөөгийн байдал” сэдвээр илтгэл тавьсан.

4. Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхмыг хэрэгжүүлэх нь” цахим сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 07-14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус сургалтад Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дорнод аймгийн нийт 119 сум, тосгоны эрүүл мэндийн төвийн ажилтнууд хамрагдсан.

5. “Гамшгийн үеийн НБНХХ-ын дэмжлэг” сэдэвт эрүүл мэндийн ажилтныг чадавжжуулах 3 хоногийн сургалтыг Завхан, Архангай,

10 дахь сал



Сүхбаатар, Хэнтий, Дорнод,
Дорноговь, Төв, Говьсүмбэр,
Дундговь аймгуудын ЭМА-
дад зохион байгуулж, нийт
115 хүн хамруулсан.


6. “Эхийн сүүгээр хооллолтыг
дэмжих 10 алхам”-ын
Үндэсний сургагч багш
бэлтгэх сургалтыг Эрүүл
мэндийн яам, НҮБ-ийн
Хүүхдийн Сан, ДЭМБ-тай
хамtran 2024 оны 10 дугаар
сарын 21-23-ны өдрүүдэд
зохион байгуулсан. НЭМҮТ,
ЭХЭМҮТ, ЭНЭМҮТ 2,
АШУУИС, нийслэлийн Өргөө,
Амгалан, Хүрээ амаржих
газрууд, Сүхбаатар,
Архангай, Дархан-Уул, Орхон
аймгийн Эрүүл мэндийн
газар, Нэгдсэн эмнэлгийн
төрөх, нярайн тасгийн
эрхлэгч, эмч, сувилагч, хоол
тэжээлийн асуудал
хариуцсан мэргэжилтэн нийт
22 үндэсний сургагч багш
бэлтгэсэн.

7. Аймаг, нийслэлийн эрүүл
мэндийн газрын хоол тэжээл
хариуцсан мэргэжилтэнүүдэд
“Давсны зохистой хэрэглээ ба
сайн туршлага”, “Шошго
хэрхэн зөв унших”, “Давсны
агууламжийг хэрхэн мэдэх”
сэдвээр богино хэмжээний
сургалт зохион байгуулсан.


8. Зудтай орон нутаг болох
Архангай, Завхан,
Сүхбаатар, Дорнод,

10 алхам

85



					Дорнговь, хэнтий, Дундговь, Говьсүмбэр, Төв аймгийн эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтын удирдамж, хөтөлбөр боловсруулж, хөтөлбөрийн дагуу 6 аймгийн 20 ЭМА-д сургалт зохион байгуулсан.		
4.5	Хүнсний аюулгүй байдлын өдөр, Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 7 хоног зэрэг Дэлхийн тэмдэглэлт өдрийг зохион байгуулах 8 сарын 2024 10 сарын 2024	Зохион байгуулсан арга хэмжээ	Тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд жил бүр үйл ажиллагаа зохион байгуулдаг	Тэмдэглэлт өдрүүдээр үйл ажиллагаа зохион байгуулна.	<p>Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих дэлхийн 7 хоногийн хүрээнд:</p> <ol style="list-style-type: none"> “Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 10 алхам зааврыг хэрэгжүүлэх нь” сэдэвт сургалтыг 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдөр танхимаар болон цахимаар зохион байгуулсан. Сургалтад нийслэлийн улсын болон хувийн хэвшлийн төрөх эмнэлэг, төрсний дараах сувилал, дүүргийн эрүүл мэндийн төвүүд, аймгийн эрүүл мэндийн газруудын чанарын менежер, төрөх, нярайн тасгийн эрхлэгч нийт 57 хүн оролцсон. 10 төрлийн инфографик боловсруулж түгээсэн. (Хандалт-127,918 Хуваалцсан- 405). Эхийн сүүгээр хооллолтыг дэмжсэн видео шторкыг НЭМҮТ-ийн цахим хуудсаар түгээсэн. (Хандалт-8107, Хуваалцсан- 109) Эхийн сүүгээр хооллолтыг дэмжсэн богино бичлэгийг 	2024.06.25 2024.12.31	100%




НЭМҮТ-ийн цахим хуудсаар түгээсэн. (Хандалт-31,001, Хуваалцсан- 163).

5. Дэлхийн 7 хоногийн уриа, мессеж агуулсан 1 төрлийн постер боловсруулж, 1000 ширхэг хэвлүүлж бүх аймгийн эрүүл мэндийн газар, дүүргийн эмнэлэг, хувийн төрөх тасагтай эмнэлгүүдэд шуудангаар илгээсэн. Хүнсний аюулгүй байдлын өдрийг тохиолдуулан:

1.“Хүүхдийн хоол тэжээлийн дутлын эмчилгээний бэлдмэлийн хангамжийн өнөөгийн байдал” зөвлөлдөх уулзалтад “Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн хангамж, хүртээмжийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр танилцуулга хийсэн.

2. Хүнсний аюулгүй байдал, хоол хүнсээр дамжих өвчин, хүнсний бүтээгдэхүүний сонголт, хүнсний харшил сэдвийн хүрээнд хүн ам олон нийтэд зориулсан нийт 8 инфографик боловсруулж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Хандалт-11328, Хуваалцсан 1615, Таалагдсан 2315

3. Нийслэлийн эрүүл мэндийн газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтэстэй хамтран Хоол тэжээл,




					<p>хүнсний аюулгүй байдал" сэдэвт цахим сургалтыг 2024 оны 10 дугаар сарын 18-ний өдөр зохион байгуулсан. Сургалтад GS25, CU, Шөлөндөө, Их Монгол Фүүдс ХХК, Блю скай ресторан, Мон сүү, Атар өргөө ХХК зэрэг газруудын нийт 105 хүн оролцсон. Сургалтад оролцогчдод цахим гэрчилгээ хүргүүлсэн.</p> <p>4. Кола хоол үйлдвэрлэлийн газрын нийт 50 ажилтнуудад Хоол хүнсээр дамжих өвчинеөс урьдчилан сэргийлэх нь сэдвээр сургалт 06.07-нд зохион байгуулсан.</p> <p>5. ТМ телевизийн оройн мэдээний хөтөлбөрт Дэлхийн хүнсний аюулгүй байдлын өдрийн хүрээнд Хүнс, хоол аюулгүй бэлтгэх 5 түлхүүр зарчим сэдвээр ярилцлага өгсөн.</p>	
--	--	--	--	--	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт


Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэ лтийн хувь
1.	Химиин хордлогын бүртгэл, тандалт, мэдээлэх үйл ажиллагааг бэхжүүлэх	Химиин хордлогын бүртгэл, тандалт, мэдээлэх журмын дагуу эмч мэргэжилтн		Сургалтын удирдамж боловсруулж, батлуулсан байна	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн мэдээлэл солилцох, эрсдэлийн үнэлгээ хийх, хариу арга хэмжээ авах, эрсдэлийн үеийн харилцаа холбоог сайжруулах, бэхжүүлэх зорилгоор	2024.06.25 2024.12.31	100%

110




		Үүдийг сургасан байна.			"Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах" журмыг танилцуулах цахим сургалтыг 6 хичээлийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн нийт 76 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.		
2.	Дэд арга хэмжээ 1.2.2 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих салбар дундын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтын зөвлөлийг байгуулах	Эрүүл мэндийн сайдын тушаал		Эрүүл мэндийг дэмжих салбар дундын зөвлөлийг байгуулна	Засгийн газрын 2023 оны 321 дүгээр тогтоолын дагуу Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих салбар дундын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг ханган ажиллах Зөвлөлийн бүрэлдэхүүн, зөвлөлийн ажиллах удирдамжийг боловсруулж, Боловсрол, шинжлэх ухааны яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Биеийн тамир, спортын үндэсний хорооноос санал авахаар 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 6/2535 тоот албан бичгийг тус тус хүргүүлэн, Саналыг тусган иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих салбар дундын нэгдсэн	2024.06.25 2024.12.31	100%


21




					удирдлага, зохион байгуулалтыг ханган ажиллах Зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, зөвлөлийн ажиллах удирдамжийн төслийг хоёрдугаар хавсралтаар боловсруулан 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн эрүүл мэндийн сайдын А/468 дугаар тушаалаар батлуулсан.		
3	Агаарын тухай хуулийн 21.4 Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид ариун цэврийн хамгаалалтын бус тогтоож, жагсаалт батлуулах.	Эрүүл мэндийн сайдын тушаал	Тушаалын төсөл боловсруулсан	Ариун цэврийн хамгаалалтын бус тогтоож, жагсаалт батлагдсан байна	Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийн хамгаалалтын бусийн хэмжээг тогтоох жагсаалтын төслийг эцэслэн боловсруулж “Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бусийн хэмжээ, Ерөнхий шаардлага MNS 5105:2001 стандарт”-д дурдагдаагүй орчиндоо эрсдэл бүхий хүчин зүйл үүсгэн үйл ажиллагаа явуулдаг 14 чиглэлийн аж ахуйн нэгж, байгууллагад эрүүл ахуйн хамгаалалтын бусийн хэмжээг тогтоох Эрүүл мэндийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн тушаалаар батлуулсан	2024.06.25 2024.12.31	100%
4	Засгийн газрын цом-2024 спортын 5 төрөлт тэмцээний хэрэгжилтийг хангах				Засгийн газрын цом-2024 спортын 5 төрөлт тэмцээнд төрийн нарийн бичгийн	2024.06.25 2024.12.31	100%



					даргын 2024 оны 11 дүгээр сарын ... өдрийн ... тоот тушаалаар ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж оролцогч яамдын шатрын тэмцээнийг амжилттай зохион байгуулж, гар бөмбөг, сагсан бөмөгийн тэмцээнд оролцсон.		
5	Эмч нарын 7р чуулган, Багийн эмч нарын анхдугаар уулзалт зохион байгуулах				Эмч нарын 7р чуулган, Багийн эмч нарын анхдугаар уулзалт зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцсон	2024.06.25 2024.12.31	100%
6	“Агаарын бохирдол ба эрүүл мэнд” нотолгооноос шийдэл рүү уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах				ДЭМБ-тай хамтран “Агаарын бохирдол ба эрүүл мэнд” нотолгооноос шийдэл рүү уулзалт хэлэлцүүлгийг 12 сарын 23нд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаад байна.	2024.12.31	100%
7	Угаарын хийн цочмог хордлогын тандалтын нэгжүүдийн бүртгэл, мэдээллийн чанарыг сайжруулах, чадавхжуулах арга хэмжээг зохион байгуулах	Бодит тоо, статистик мэдээ, зөвлөмж, уулзалт, сургалтын тоо		Угаарын хийн хордлогод өртсөн, нас барсан иргэдийн тоог гаргах, эрсдэлийг бодитоор үнэлж, чадавхижуул ах уулзалт, сургалтыг зохион байгуулсан байна.	Угаарын хийн хордлого: ЦТЭ-ийн харьяа ХЯТҮТ, ЭХЭМҮТ, НЭМГ, 21 аймгийн ЭМГ-аас өдөр бүр мэдээ авч, нэгтгэн УОК-ын Нэгдсэн шуурхай штаб-д хүргүүлсэн. 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар Нийслэлийн 7 дүүрэг, 10 аймагт нийт 2489 хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан. 2024 онд химийн хордлогын үйл явдлын 6	2024.12.31	100%



тохиолдолд эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээг хэрэгжүүлсэн. НЭМҮТ-ийн Хор судлал, шуурхай удирдлагын алба, ЭМЯ-ны Хор судлалын мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтран Хими, нүүрстөрөгчийн дутуу ислийн цочмог болон архаг хордлогын үеийн тусlamж үйлчилгээ, ялан оношлох, олныг хамарсан гамшиг ослын үед эмнэлгийн тусlamжийг зохион байгуулах мэдлэг чадвар эзэмшүүлэх зорилгоор "Химийн бодис, нүүрстөрөгчийн дутуу ислийн хордлогын үеийн тусlamж үйлчилгээ" сэдвээр цахим сургалтыг 5 хичээлийн хүрээнд 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулж, 21 аймаг, 9 дүүргийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн төвүүд, нэгдсэн эмнэлгүүд, БОЭТ-ийн нийт 100 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулсан.



Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур Үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэ лтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн сургалтад хамрагдах	Гэрчилгээ, сертификат	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалтад хамрагдсан.	Сургалтад тухай бүр хамрагдсан байна	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалтад хамрагдсан.	2024.06.25 2024.12.31	100%
2.	Англи хэлний түвшин дээшлүүлэх сургалтыг сургалтын байгууллагаар болон бие даан суралцах	Гэрчилгээ, сертификат		Сургалтад тухай бүр хамрагдсан байна	Сургалтад хамрагдсан	2024.06.25 2024.12.31	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХТХАБАА хамгийн чижинчт
(Албан тушаал)

Ж. Аялансуур / /
(Нэр, гарын үсэг)

2024.12.05
(Огноо)

561

